



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Өргөдлийн байнгын хорооны 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

Хэлэлцсэн нь:

Иргэн Г.Ганчимэг, Ц.Ренчиндорж нараас “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтэй холбоотой хуулийн заалт хэрэгжихгүй байгаа” асуудлаар ирүүлсэн өргөдлийн хүрээнд Хөдөлмөрийн сайд С.Чинзоригийн мэдээллийг сонсож, хуулийн хэрэгжилтийг хэлэлцсэн тухай

Шийдвэрлэсэн нь:

Хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах талаар Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т дараах чиглэлийг өгөх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1/Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.7 дахь хэсэгт заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хараагүй хүнийг ажиллуулах ажлын байрны жагсаалтыг баталж мөрдүүлэх, цаашид уг жагсаалтыг “тэргүүн ээлжинд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах ажлын байрны жагсаалт” гэсэн томъёоллоор өөрчлөх талаар судлах;

2/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төвлөрүүлсэн хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхлэх боломжтой ажил, мэргэжлийн жагсаалтад заасан мэргэжлийг эзэмшүүлэх, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулахад зарцуулах;


3/Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдсон хуулийн зүйл, заалтыг хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах үүднээс төлөөллийн байгууллагатай гэрээ байгуулан хамtran ажиллах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх;

4/Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийн хэрэгжилт төрийн байгууллагуудад хангалтгүй байгааг анхаарч зохих арга хэмжээг авах;

5/Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу 2015 оны хаврын чуулганы хугацаанд холбогдох арга хэмжээг авч, тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



О.БААСАНХҮҮ

Г.НЯМСҮРЭН